

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



www.audit.mn

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Баянхонгор 2019 он

АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт:.....	3
Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудит:	5
Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар:	9
Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар:	10
Зургаадугаар бүлэг: Дотоод ажлын талаар:	16
Долоодугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл:.....	24

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.12.04.

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт:

Үндэсний аудитын газраас 2019 оныг “**Аудитыг баримтжуулах бодлого, арга зүйг боловсронгуй болгож, төлөвшүүлэх**” жил болгосон зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь дэд төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд ажлаа чиглүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Зорилтыг хангах ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Дэвшүүлсэн зорилттой уялдуулан ББНШК-ын хийх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ББНШК-ын зүгээс 2 удаа шалгалт хийж дүнг удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж мөн хэвлэмэл хуудасны тооллогыг жилийн эцсийн байдлаар хийж баталгаажуулж аймгийн Архивын тасагт хүргүүлж ажиллав.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн дагуу аймгийн салбар комиссын үзлэгээр 98 хувьтай буюу “Маш сайн” гэж үнэлэгдэв.
- Төрийн аудитын байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд зарласан уралдааны удирдамжийн дагуу “Нийцлийн аудитыг баримтжуулж байгаа өнөөгийн нөхцөл байдал, арга зүйг боловсронгуй болгох нь” сэдэвт илтгэлийг бэлтгэн, 2019 онд хийсэн ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын ажлын баримт, CD-ний хамт ҮАГ-ын НАГ-т хүргүүлсэн.
- Дарга, тэргүүлэх аудиторов зүгээс үйл ажиллагааны календарьчилсан төлөвлөгөөний самбар гаргаж, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажиллав.
- Аудитын зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын чанарыг үнэлэх самбар гарган, аудитын үе шат бүрд бүрдүүлсэн нотлох баримтыг үзэж, чанарын хяналтын




хуудсаар үнэлгээ өгч ажилласнаар аудитын нотлох баримтын бүрдүүлэлтэд ахиц гарлаа.

- 2019 онд хийгдсэн гүйцэтгэл болон нийцлийн аудитын 15 тайлангийн ажлын баримтыг СД-нд хуулж, цахим архив бүрдүүлэх зорилт дэвшүүлэн хийж гүйцэтгэв.



- Долоо хоног бүрийн шуурхай хуралдаанд хийх ажлын төлөвлөгөө болон үүрэг даалгаврыг сарын турш нэг ажилтан хариуцаж, ABLE программын ажил үүрэг цэсийг ашиглан хэрэгжилтийг гарган мэдээлэл хийснээр ажилтнуудын манлайлах байдал сайжирч идэвхтэй болж, ажлын гүйцэтгэл дээшилж, бие биедээ тавих шаардлагад тодорхой ахиц гарч байна.



- Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан, сургалтын сэдвийг ажилтнуудад хуваарилан өгч 14 хоногт 1 удаа дотоод сургалтыг явуулж хэвшсэн ба сургалтыг хийж буй аудиттай уялдуулан кейс ажиллах, ярилцлага, АХА тэмцээн явуулах, дотоод мэдээллийн сангийн Цахим тестийн сангаас хооронд нь уралдаан зохион байгуулах зэргээр шинэлэг арга хэлбэрийг хэрэгжүүлснээр сургалтын үр нөлөө дээшилж, ажилтнуудын ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд зохих үр дүн өгч байна.

Тус газар нь Монгол улсын Ерөнхий аудиторын 2017.04.20-ны А/69 тоот тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж, Тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор 2, аудитор 4, хүүхдээ асрах чөлөөтэй 2 аудиторын оронд түр орлон гүйцэтгэгч 2, жолооч 1 нийт 11 орон тоотой ажиллалаа.

2019 оны байдлаар нийт 19160 хүн/цаг ажиллахаас 21511 хүн/цаг ажиллаж, 2351 хүн/цаг илүү цагаар ажилласан байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 171 санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргаж, “Хязгаарлалттай”, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт авсан болон санхүүгийн тайлан гаргаж аудит хийлгээгүй 9 байгууллагын удирдлагад “Төрийн аудитын тухай хуульд нэмэлт

өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн 28 дугаар зүйлд зааснаар сахилгын шийтгэл ногдуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хэрэгжүүлэв.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар төлөвлөгөөт гүйцэтгэлийн 3 аудит, нийцлийн 3 аудит, санхүүгийн аудит 1, аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэлийн 1 аудит, нийцлийн 2 аудит, өөрсдийн санаачилгаар гүйцэтгэлийн 3 аудит, нийцлийн 1 аудит, санхүүгийн 1 аудит буюу нийтдээ 15 аудит буюу гүйцэтгэлийн 7 аудит, нийцлийн 6 аудит, санхүүгийн 2 аудитыг тус тус гүйцэтгэж, тайлан, судалгааг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэв.

2019 онд хийгдсэн санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар нийт 14678,7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 735,5 сая төгрөгийн 97 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 7306,8 сая төгрөгийн 59 албан шаардлага хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 6008,5 сая төгрөгийн 221 заалт бүхий зөвлөмж өгч, 627,9 сая төгрөгийн 89 алдааг санхүүгийн тайланд залруулж, нийтдээ 7177,1 сая төгрөгийн үр өгөөж тооцон хүлээн зөвшөөрүүлж, зардлын 1 төгрөг тутмаас 26.68 төгрөгийн үр өгөөжтэй буюу өмнөх оноос 46%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй ажиллалаа.

Хүснэгт №1. Тайлант оны дүнгээр нийт Илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт /сая.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОГТООСОН		ХЭРЭГЖСЭН		
	Тоо	дүн	Тоо	дүн	Хувь
ТӨЛБӨРИЙН АКТ	97	735,5	91	680,2	92,5
АЛБАН ШААРДЛАГА	59	7306,8	54	6254,7	85,6
ЗӨВЛӨМЖ	221	6008,5	219	6006,6	99,9
НИЙТ ДҮН	377	14050,8	364	12941,5	92,6

2019 оны байдлаар актын төлбөрийг 92,5% буюу 680,2 сая төгрөгийг, албан шаардлагын 85,6% буюу 6254,7 сая.төгрөгийг тус тус барагдуулж, 6006,6 сая төгрөгийн өмнөх оны 25, тайлант оны 194 нийт 219 зөвлөмж хэрэгжиж, хэрэгжилт 99,9%-тай гарлаа.

Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудит:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9-д заасан хугацаанд 17 сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Нийгмийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн салбарын санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сан /Улсын төсөв/ зэрэг 24 төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг болон

төсвийн ерөнхийлөн захирагчдаас санхүүждэг төсвийн шууд захирагчийн 151 байгууллага, нийт 175 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргахаас Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэг, “Баянхонгор Нью-майнинг” ХХК, “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААТҮГ зэрэг 4 байгууллага Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлан гаргаж ирүүлээгүй тул аудитад хамрагдаагүй болно. Мөн төлөвлөсний дагуу аймгийн ТЭЗ-чийн 2018 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, тусгай сан, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 264 байгууллага санхүүгийн тайлан гаргахаас 98.5% буюу 260 байгууллага Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайланг ирүүлсэн бөгөөд 33 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгээгүй, 56 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан байгууллагын тоо өмнөх оноос 53-аар буурсан нь 2018 онд орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж дүгнэлт өгөөгүйтэй холбоотой байна.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлангаас 141 байгууллага, аж ахуйн нэгж, тусгай сан, сумдын санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрсдийн аудиторуд, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/191 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад шалгарсан “Хонгорын үр сад аудит”, “Глобал капитал аудит” компаниудтай 30 байгууллагын санхүүгийн тайланд гэрээ байгуулж аудит хийж дүгнэлт гаргав.

Дээрх 2 аж ахуйн нэгж нь гэрээнд заасан хугацаанд аудитыг гүйцэтгэж, аудитын дүгнэлт, ажлын баримт материалуудыг хугацаанд нь ирүүлэв.

Аудитад хамрагдсан нийт 171 байгууллагын санхүүгийн тайлангийн 2.3% буюу 4 тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргаж, “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзаж, 97.1%-д “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.



Аудитад Төрийн аудитын байгууллагын 10, хараат бус аудитын 2 компанийн 8, /давхардсан тоогоор 44 хүн/ нийт 18 хүн, 903 өдөр ажиллаж, 1913 илүү цаг зарцуулсан байна.

МУЕА-ын 2018 оны 04 дүгээр сарын 12-ны А/64 тоот тушаалаар батлагдсан “Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал” –ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд СУГ-аас ирүүлсэн хялбаршуулсан загварыг ашиглан 2019 онд гэрээгээр аудит хийсэн аудитын 2 ХАК-нийн ажлыг үнэлж, Дарга, тэргүүлэх аудитор баталгаажуулав.

Санхүүгийн аудитаар нийт 1719,0 сая, төгрөгийн зөрчил илэрснээс 627,9 сая төгрөгийн 89 алдааг санхүүгийн тайланд нь залруулж, 279,3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 101,1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 710,7 сая төгрөгийн зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн 90 заалт бүхий зөвлөмжийг төсвийн менежерүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах аяны хүрээнд зөрчлийг бүрэн арилгаж, барагдуулав. Аудитаас 603,1 сая төгрөгийн үр өгөөж тооцож бүртгэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” болон “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан 5 байгууллага, санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй 4, нийт 9 байгууллагын удирдлагад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг “Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 28 дугаар зүйлд заасны дагуу томилсон албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажиллав.

Төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн сахилга бат, төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс сумдын Засаг дарга,



ИТХ-ын нарийн бичгийн дарга, ТШЗ-чид, санхүүгийн ажилтнуудад холбогдох байгууллагуудтай хамтран СТА-ын дүн, цаашид анхаарах асуудлын талаар удаа дараа мэдээлэл өгч, хэлэлцүүлэг ярилцлага хийсэн ба завсрын аудитын явцад илэрч буй алдаа, зөрчилд үндэслэн жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахад анхаарах асуудлын талаар аймгийн СТСХ-ийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд мэдээлэл бэлтгэж хүргүүлэн ярилцлага хийсэн болон сумдын Засаг дарга нарт мөн мэдээлэл өгч ажилласнаар төсвийн байгууллагын санхүүгийн сахилга зохих хэмжээгээр дээшилсэн дээрх графикаас харагдаж байна.

2019 онд санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн тайлант оны албан шаардлага, актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан ба төлбөрийн актаас 36,4 сая төгрөгийг аймгийн болон орон нутгийн төсөв, татварын орлогод, 234,1 сая төгрөгийг тусгай санд /онхс, схс/ төвлөрүүллээ.

Өмнөх оны 3 албан шаардлагын 58,3 сая төгрөгөөс 1 албан шаардлагын 10,0 сая төгрөг барагдаагүй байгаа нь Жаргалант сумын СХС-гийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл бөгөөд хуулийн байгууллагад шилжүүлсэн боловч эзэн холбогдогчийн хаяг тодорхойгүй гэсэн шалтгаанаар шийдвэрлэгдэхгүй байгааг ҮАГ-ын орон нутаг хариуцсан ажлын албаны шалгалтын хэсгийн өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу тухайн сумдын Засаг даргад дахин албан тоотоор хандсан одоогоор хэрэгжээгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 3 хүн 7 өдөр зарцуулж, 224.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, төсвийн төлөвлөлттэй холбоотой 14.1 сая

төгрөгийн үр өгөөж тооцож, ҮАГ-аас ирүүлсэн судалгаануудыг бүрэн гаргаж, холбогдох байгууллагуудад аудитын тайланг хүргүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн акт, албан шаардлага, зөрчлийн талаар нэгдсэн танилцуулга бэлтгэж, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлж ажиллалаа.

Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар:

Байгууллагын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашиг”, “Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал”, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, нийт 68 байгууллагыг хамруулж, давхардсан тоогоор 9 хүн аудитыг гүйцэтгэж, 106 өдөр зарцуулж, 320 цаг илүү ажиллав.

Аудитаар 3771,3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс, 99,9 хувь буюу 3769,4 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, 1110,5 сая төгрөгийн үр өгөөж тооцож, холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, өмнөх оны 56.3 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдлийн биелэлтийг хангуулж, тайлант оноос 1,9 сая төгрөгийн 8 заалт бүхий зөвлөмж, 2 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Хүснэгт №2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчил /сая.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОГТООСОН		ХЭРЭГЖСЭН		
	Тоо	дүн	Тоо	дүн	Хувь
ТӨЛБӨРИЙН АКТ	7	23,8	7	23,8	100
АЛБАН ШААРДЛАГА	8	2676,6	6	2676,6	100
ЗӨВЛӨМЖ	21	1070,9	13	1069,0	99,8
НИЙТ ДҮН	36	3771,3	26	3769,4	99,9

1. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитыг 2 хүн 36 өдөр зарцуулж, 27 байгууллагыг хамруулан гүйцэтгэж тайланг 2019.04.10-ны өдөр ҮАГ-ын ГАГ-т хүргүүлсэн ба аудитаар 2676.6 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч, зөрчлийг арилгах албан шаардлага өгч мөн аймгийн Засаг даргад 4 заалт бүхий зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан ба аудитаар 1086,7 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж ажиллав.

Аудитын тайлантай холбогдуулан тайлант онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийн магадлалын дүгнэлт төсөв батлагдах үед хийгдээгүй байдаг зөрчил дутагдал арилахгүй байгаа тул уг асуудлыг холбогдох байгууллагад асуудал тавьж зогсоох арга хэмжээ авах, мөн төсөл арга хэмжээний дутуу хийгдсэн ажлын гүйцэтгэлд гарын үсэг зурж санхүүжилтийг бодит

гүйцэтгэлээс илүү олгосон Барилгын хөгжлийн төвийн холбогдох албан тушаалтнуудад хариуцлагын арга хэмжээ авах саналуудыг ГАГ-т хүргүүлэв.

2. “Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал”-д хийсэн аудитыг 2019.10.18-2019.11.01-ыг хүртэлх хугацаанд 3 хүн 32 өдөр зарцуулан ажиллаж, аудитын тайлан, судалгааг ГАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

Аудитаар хувийн өмчийн цэцэрлэгүүдэд санхүүжилтийг гүйцэтгэлээс илүү олгосон, зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрч 23,8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, бүрэн барагдуулсан бөгөөд сургалтын орчин сайжруулах, сургалтын ахиц амжилтын үнэлгээнд дүн шинжилгээ хийх 2 төрлийн албан шаардлага, ажил сайжруулах, үр ашиг дээшлүүлэх 6 төрлийн зөвлөмжийг хүргүүлсэн ба хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

3. “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн аудитыг аймгийн НДС-гийн 2012-2018 оныг хамруулан 4 хүн 38 өдөр зарцуулж, 200 цаг илүү ажиллаж, тайланг 2019.11.15-ны өдөр ГАГ-т хугацаанд нь хүргүүлэв.

Аудитаар нийт 312.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөлтэй холбоотой 1 албан шаардлагыг хүргүүлэв. ҮАГ-ын ГАГ-аас өгсөн чиглэлийн дагуу аудитаар тогтоосон 42.1 сая төгрөгийн төлбөрийн актыг статистик мэдээнд оруулаагүй хүлээгдэж байгаа болно.

Аудитаар илэрсэн зөрчлийн цаашид засаж залруулах, үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг бүрэн биелүүлж иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байх 11 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын тасагт хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар:

Тайлант онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт”, “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”, “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх” зэрэг 3 нийцлийн аудитыг давхардсан тоогоор 7 хүн 95 өдөр ажиллан гүйцэтгэсэн байна.

Аудитаар нийт 3507.0 сая төгрөгийн зөрчил илэрч, нийт 1843,3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн ба 55,3 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 2 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Хүснэгт №3. Нийцлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт /сая.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОГТООСОН		ХЭРЭГЖСЭН		
	Тоо	дүн	Тоо	дүн	Хувь
ТӨЛБӨРИЙН АКТ	22	228.7	16	173.3	75.8
АЛБАН ШААРДЛАГА	19	1065.9	19	1065.9	100
ЗӨВЛӨМЖ	35	2212.4	33	2212.4	94.3
НИЙТ ДҮН	76	3507.0	76	3451.6	90.0


2019 оны эхэнд өмнөх онд ОНХС, СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар зөрчлийг арилгахаар 17 заалт бүхий зөвлөмж, 42.9 сая төгрөгийн 3 заалт бүхий албан шаардлага өгснийг тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажиллав.

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн аудитыг 2 хүн 21 өдөр ажиллаж 21 байгууллагыг хамруулан, тайланг баталгаажуулж 2019.04.09-ны өдөр ҮАГ-ын НАГ-т хүргүүллээ.

Аудитаар ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлээгүйгээс зэргээс нийт 884,5 сая төгрөгийн зөрчил илэрч, 1.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 822.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 13 албан шаардлага, 61.0 сая төгрөгийн зөрчил арилгах 12 заалт бүхий зөвлөмжийг аймаг, сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлснийг биелүүлж, 141.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн.

2. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитад Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах 230 байгууллагыг аудитад хамруулан, 3 хүн 42 өдөр зарцуулан хугацаанд нь гүйцэтгэж, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Аудитаар 2395,1 сая төгрөгийн зөрчил илэрч 243,7 сая төгрөгийн 6 албан шаардлага өгч, 2151.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас тавьж буй мэдээллийн агуулга, чанарт анхаарч ажиллахгүй байна гэсэн



дүгнэлт өгч, тус аудитаар гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар мэдээлэл бэлтгэж, байгууллагуудад хүргэсэн ба аудитаар өгсөн албан шаардлагыг хугацаанд бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллав.

3. “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх”-д хийсэн аудитыг аймгийн ГХБХБГ болон 20 сумдыг хамруулан 2 хүн 32 өдөр гүйцэтгэн 2015-2018 оны газар олголтын байдлыг шалгаж, тайланг байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар баталгаажуулж 2019.06.09-ны өдөр холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитаар Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах зарим шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн зөрчил илэрч 227.4 сая төгрөгийн зөрчил илэрч 20 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх 18 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн ба төлбөрийн актын 75.6 хувийг буюу 172.0 сая төгрөгийн актыг барагдуулсан бөгөөд нийт 917,3 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн.

Тавдугаар бүлэг. ИТХ-ын захиалга болон өөрийн санаачилга:

Аймгийн ИТХ-аас ирүүлсэн захиалгын дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудит, аймгийн “Цагдаагийн газрын журмын хашааны орлогыг хууль, тогтоомжийн дагуу бүрэн төвлөрүүлсэн эсэх, түүний зарцуулалт”, “Чандмань- Баянхонгор” ХК-ийн 2015-2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д нийцлийн аудит хийж нийт 1475,3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, тайлант онд хийсэн аудитаар 233.8 сая, өмнөх онд гүйцэтгэсэн аудитаар 192.0 сая, нийт 425.8 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн байна.

1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг 2 хүн 26 өдөр гүйцэтгэж, нийт 1073.9 сая төгрөгийн 17 зөрчил илрүүлснээс 14.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1059.0 сая төгрөгийн 16 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Аудитаар Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан зардлыг хэтрүүлсэн, хандив тусламж олгосон, холбогдох шийдвэргүй хөрөнгө зарцуулсан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зэргээр орон нутгийн өмчийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулаагүй, өмнөх оны цахилгааны авлага, техникийн нөхцөлийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, урт хугацаат зээлийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулаагүй, хяналтын зөвлөлийг томилоогүй зэрэг зөрчил илэрсэнд холбогдох эрх бүхий 4 албан тушаалтанд зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмж хэрэгжээгүй байна.

2. “Цагдаагийн газрын журмын хашааны орлогыг хууль, тогтоомжийн дагуу бүрэн төвлөрүүлсэн эсэх, түүний зарцуулалт”-д хийсэн аудитыг 2016-2018 оныг хамруулан 2 хүн 10 өдөр зарцуулж, хамгаалалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгж гэрээнд заасны дагуу тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаанд журамлагдсан тээврийн хэрэгслээс авах төлбөр хураамжийн 30% -ийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр заасан байхад 3.1 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах 3 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж биелэлтийг тооцож ажиллав.

3. “Чандмань- Баянхонгор ХК-ийн 2015-2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д 2 хүн 27 өдөр зарцуулж, Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж 2019.06.25-ны өдөр байгууллагын УЗХ-аар хэлэлцүүлэн батлуулж, тайланг аймгийн ИТХ, холбогдох бусад байгууллагад хүргүүлэв. Аудитаар 398,2 сая төгрөгийн зөрчил илэрч 55.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 342,3 сая төгрөгийн 15 заалт бүхий зөвлөмжийг өгч биелэлтийг хангуулж ажилласан бөгөөд аудитаар 230,7 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн.

 **Байгууллагын өөрийн санаачилгаар** тайлант онд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Замын сангийн 2018 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн” сэдэв бүхий 2 гүйцэтгэлийн аудит, “Ус рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдал хууль тогтоомжид нийцэж буй эсэх”-д нийцлийн аудит, “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д санхүүгийн аудит хийж, нийт давхардсан тоогоор 11 хүн 109 өдөр ажиллав.



Аудитаар нийт 4206,1 сая төгрөгийн зөрчил илэрснээс төлбөрийн актын 144,6 сая төгрөгийг бүрэн барагдуулж, албан шаардлагаас 2395.8 сая төгрөгийн барагдуулсан байна. Харин 1052,5 сая төгрөгийн 5 албан шаардлага,

14 заалт бүхий зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогой байна.

Өмнөх онд гүйцэтгэсэн “Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт хадгалалт, хамгаалалтын байдал”-д хийсэн нийцлийн аудитаар өгсөн 8 заалт бүхий зөвлөмж, 45.0 сая төгрөгийн албан шаардлага бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

1. “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитыг 2 аудитор 24 өдөр зарцуулан гүйцэтгэж 2019.05.15-нд тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Аудитаар 158,7 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч, 4.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 154.0 сая төгрөгийн 4 төрлийн зөрчлийг арилгах албан шаардлага өгснийг бүрэн барагдуулсан бөгөөд ажил сайжруулах, үр ашиг дээшлүүлэх 210.8 сая төгрөгийн 7 төрлийн зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан байна.

2. “Баянхонгор аймгийн авто Замын сангийн 2018 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн”-д хийсэн аудитыг 2 аудитор 14 өдөр зарцуулан, аудитын тайланг 2019.06.21-ны өдөр батлуулж, аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитаар нийт 281,1 сая төгрөгийн зөрчил илэрч арилгаж, 5 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн хэрэгжилтийг тооцож, аудитаар 24,5 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэв.

3. “Ус, рашааны төлбөр ногдуулалт, төлөлт нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх”-д хийсэн 3 хүн 22 өдөр ажиллаж, аудитын тайланг 2019.09.25-

ны өдөр удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллагад хүргүүлэв.

Аудитаар 1191.1 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч, 139.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1051.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, цаашид орлого нэмэгдүүлэх боломж, албан тушаалтнууд ажлын хариуцлага, хяналтаа сайжруулах, өмнөх зөрчлийг арилгах давтан гаргахгүй байхад чиглэсэн 14 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

Тухайн онд 139,9 сая төгрөгийн акт болон зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажилласан бөгөөд ус рашаан ашигласны төлбөрийн дутууд өгсөн 1051,2 сая төгрөгийн албан шаардлагын хариуг 2020.06.01-нд багтааж барагдуулахаар ажиллаж байна. Мөн ус рашаан ашигласны төлбөрийг 249.0 сая төгрөгийг аудитын явцад барагдуулсныг аудитын үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүлэв.

4. “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн санхүүгийн аудитыг 3 хүн 34 өдөр зарцуулж, нийт 2363.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс, 1961.2 сая төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага, 402.4 сая төгрөгийн 15 зөрчилд зөвлөмж хүргүүлж, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллав.

Аудитаар зарим сумдын ИТХ-ын хуралдаан сумын төсвийг зөрүүтэй баталсан, батлагдсан төсвийг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан, өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил дахин давтагдан гарсан, сумдын татварын орлогын гүйцэтгэл, төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан, аймгийн Орон нутгийн өмчийн газраас төсөвт байгууллагуудын байр ашиглалт, сум хөгжүүлэх сангийн программын ашиглалтын байдалд хяналт тавиагүй зэрэг зөрчилд зөвлөмж, албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцон ажилласан байна. Тухайлбал:

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр сум бүрт зээлийн мэдээллийг бүртгэх программыг ашиглах албан шаардлага өгсний дагуу сангийн программын төлбөрийг бүрэн барагдуулж, бүх сумдын сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдлийг программд бүрэн оруулж ашиглаж эхэлсэн анхны аймаг болсон амжилттай байгаа нь төрийн аудитын байгууллагаас өгсөн мэргэжил арга зүйн зөвлөгөө нь үр дүнд хүрч аудитын үр өгөөж гарсан тухай аймгийн ХХААГ-аас 2019.12.04-ний өдөр 3/386 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Зургаадугаар бүлэг: Дотоод ажлын талаар:**Хүний нөөцийн талаар:**

Тус газрын батлагдсан орон тоо 11 ба үүнээс хүүхэд асрах чөлөөтэй 2 ажилтны оронд түр орлон гүйцэтгэгчээр 2 аудитор МУЕА-ын тушаалаар томилогдон ажиллаж байна. Төсөвт тусгагдсаны дагуу байгууллагын нягтлан бодогч, архив бичиг хэргийн 1 ажилтан ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд 2 гэрээт аудитор ажиллуулж, 1 гэрээт аудиторыг 2019 оны 3 дугаар сарын 01-нээр, 1 гэрээт аудиторыг 4-р сарын 1-нээр тасалбар болгон чөлөөлсөн болно.

Тайлант хугацаанд хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээлэл, тайлант хугацаанд нь тогтмол ҮАГ-ын хүний нөөцийн албанд хүргүүлсэн ба Төрийн албаны хүний нөөцийн системд ажилтнуудын мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулав.

2019 оны 05 дугаар сард нийт ажилтнуудыг Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, 11-р сард Улсын нэгдүгээр эмнэлгийн эмч нарын урьдчилсан сэргийлэх үзлэг, шинжилгээнд ажиллагсад хамруулав.



Төрийн албаны шинэчилсэн хууль болон архивын улсын үзлэгийн хүрээнд ажилтнуудын хувийн хэргийг шинэ журмын дагуу шинэчлэн ажлын байрны тодорхойлолтоор /МУЕА-ын 2019.10.08-ны А/78 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг ажилтнуудад танилцуулж/ баяжуулав.

Албан хаагчдын мэдлэг, чадвар, туршлагыг дээшлүүлэх, идэвхжүүлэх зорилгоор 2018 оны ажлаараа ҮАГ-ын салбарын хэмжээнд 2-р байрт шалгарсан Говь-алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2019.07.01-04-ны хооронд Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олонтой хамтран туршлага судалж, аудитад тулгарч байгаа асуудлаар харилцан санал бодлоо солилцон, ажлын мэдлэгээ хуваалцсан үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан.



ҮАГ-с зохион байгуулсан Сургагч багш нарын давтан сургалтад оролцогчдод урьдчилан сэдэв хуваарилсаны дагуу хичээл бэлтгэн заах арга хэмжээг зохион байгуулсан нь багш нарт их үр дүнгээ өгсөн. Энэ арга хэмжээнд тус газрын аудитын менежер А.Цээням “Санхүүгийн тайлангийн аудитын тайлан ба хураангуй тайлан бэлтгэх арга зүй” сэдвээр заасан хичээл ҮАГ-ын хэмжээнд 1-р байрт шалгарсан.

Мэдээ тайлан гаргалтын талаар:

Байгууллагын 2018 оны статистик мэдээг батлагдсан маягтын дагуу гаргаж, тайлан бичиж 2019.01.06-нд, 2019 оны эхний хагас жилийн статистик мэдээг цаасаар болон цахимаар ҮАГ-ын Тамгын газар, Орон нутаг хариуцсан ажлын алба, СУГ-т 2019.06.20-нд хүргүүлж ажиллав.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, дарга, тэргүүлэх аудиторын үр дүнгийн гэрээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улирлын байдлаар гарган ҮАГ-ын Тамгын газар болон Орон нутаг хариуцсан ажлын албанд хугацаанд нь хүргүүлэв.

Байгууллагын хүний нөөцийн хөдөлгөөний тайлан, сарын ажлын тайланг сар бүр гаргаж, ҮАГ-ын орон нутаг хариуцсан ажлын алба, Тамгын газрын Хүний нөөцийн албанд тогтоосон хугацаанд тогтмол хүргүүлсэн.

ҮАГ-ын СУГ, НАГ, ГАГ, Тамгын газраас цаг үеийн ажилтай холбогдож шаардсан мэдээ, мэдээлэл, судалгаа, ажлын тайланг тухай бүр гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд МУЕА-с өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

Дотоод сургалтын талаар:

Төрийн аудитын газрын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийн хүрээнд МУЕА-н орлогчийн 2019.03.06-ны өдрийн А/22 тушаалаар батлагдсан 2019 оны сургалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу тус газрын 2019 оны дотоод сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан, байгууллагын ажилтнуудад зориулсан 2019 оны

дотоод сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан баталж, календарчилсан хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулж байна.

2019 онд санхүүгийн тайлангийн аудит, СТАУС программын ашиглалт сэдвээр 2 гэрээт аудитор, ХАК-ны аудитор нарт сургалт зохион байгуулав. Мөн аудитор нарт санхүү, гүйцэтгэл болон нийцлийн аудит, архив бичиг хэрэг, мэдээллийн технологи, хууль, эрх зүй, төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр ажилтан, нарт дотоод сургалтыг 14 хоног тутамд Пүрэв гаригт 16 цагаас сургалт хийж, нийт дотоод сургалт 21 үүнээс хамтарсан сургалт 4-г зохион байгуулж, давхардсан тоогоор 224 хүн хамрагдсан байна.

2019 онд дэвшүүлсэн “Аудитыг баримтжуулах бодлого, арга зүйг боловсронгуй болгож, төлөвшүүлэх жил” зорилтын хүрээнд Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн даргаар “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчлэл, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Төрийн албан хаагч нь санаатай болон санамсаргүй байдлаас болж авлигын хэрэгтэй холбогдвол түүнийгээ хэрхэн зөв шийдэх”, аймгийн Прокурорын газраас урьж “Нотлох баримт, баримт бүрдүүлэлтийн талаарх хууль зүйн ойлголт”, зэрэг дотоод сургалт зохион байгуулав.

ҮАГ-аас зохион байгуулсан нягтлан бодогч нарыг чадавхжуулах сургалтад байгууллагын нягтлан бодогч П.Амаржаргал, ТАБ-ын Архив албан хэрэг хариуцсан ажилтнуудын сургалт, Сургагч багш нарын давтан сургалтад ахлах аудитор А.Цээням, ТАБ-ын Мэдээллийн технологийн ажилтнуудын сургалтад ахлах аудитор Б.Азбаяр оролцож, ахлах аудитор нарын сургалтад Б.Азбаяр, Б.Должмаа, аудитор Н.Бүнчинсүрэн нар оролцож, ажилтнуудад сургалтыг тухай бүр нь зохион байгуулж ирлээ.

Олон нийттэй харилцах ажлын талаар:

Аудитын дүнг олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангах үүднээс аймгийн "Өнөөгийн Баянхонгор" сонинд Санхүүгийн тайлангийн аудит хийгдсэн бүх байгууллагын аудитын дүгнэлтийг жагсаалтаар нийтэлсэн ба тайлант хугацаанд 13 аудитын дүнг сонинд мэдээлж, аудитын үйл ажиллагаатай холбоотой 47 мэдээлэл, цаг үеийн шинжтэй 25 мэдээллийг www.audit.mn; вэб сайтад байршуулсан.

Гүйцэтгэл, нийцлийн 2019 онд хийгдэх аудит болон бусад ажлыг цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлэх ажлын төлөвлөгөө гарган хяналтын самбарыг хөтөлж цаг тухай бүрд нь мэдээллийг байршуулж байна Тухайлбал:

Аудитын төлөвлөгөө 6, аудитын тайлан 14, зөвлөмж 7, албан шаардлага 9, акт 9, шийдвэрийн биелэлт 1-ийг цахим сайтад QR кодоор тамгалан зааврын дагуу байршуулав.



Тайлант онд давхардсан тоогоор 81 аудитын тайланг бусдад хувилж өгсөн байна.

Төрийн аудитын байгууллагын чиг үүргийг таниулан сурталчлах зорилгоор Шинэжинст, Баянбулаг, Эрдэнэцогт сумдад нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 25 байгууллага, 147 иргэнд аудитын талаар мэдээ мэдээлэл хийж, төрөлжсөн аудитын талаар танилцуулсан 600 ширхэг тарааж өгөх материалыг иргэдэд хүргэж ажиллав.



Тухайлбал:

- Санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн тухай танилцуулга, зөвлөмж бэлтгэж аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргад хүргүүлээ.
- 2019 онд хийсэн Санхүүгийн тайлангийн аудитын дүн, ОНХС, Шилэн дансны аудитаар илэрсэн зөрчил дутагдал цаашид анхаарах асуудлын талаар сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, сумдын санхүүгийн албаны дарга нарт мэдээлэл өгч, ярилцлага хийв.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгож зарласантай холбогдуулан Баянхонгор аймагт 2019.01.28-ны өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад Төрийн аудитын байгууллагын талаарх мэдээллийг иргэдэд түгээж, ТАБ-ын шторкыг цахим самбараар нийтэд сурталчлан ажиллалаа.


Мэдээлэл технологийн ажлын талаар:

Ажилчдын суурин болон зөөврийн компьютерийн хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангах зорилгоор мэдээллийн технологийн албанд хэрэглэгдэж

буй компьютерийн бүртгэлийг хүргүүлж хортой код хамгаалах программын эрхийг 2019 оны 3 дугаар сард сунгуулав.

ҮАГ-аас ирүүлсэн “Болор дуран” программыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер, бичиг хэргийн ажилтан, ахлах аудитор нарын компьютерт суулгаж үгийн алдаагүй бичихэд хяналт тавих нөхцөл бололцоог хангаж ажиллав.

Архивын улсын үзлэгийн хүрээнд архивын өрөөнд камер суурилуулан нууцын өрөөний серверт холболоо.



Серверийн өрөөний камер



Архивын өрөөний камер

Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас “Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ”-г 2019 оны 6 дугаар сард хийлгэж ирүүлсэн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган тэргүүлэх аудитораар батлуулж, төлөвлөгөөний дагуу аймгийн тагнуулын газраас “Мэдээллийн аюулгүй байдал” сэдвээр сургалт авч, мөн сүлжээний топологи зураглал гарган, албан хэрэгцээний компьютеруудын үйлдлийн систем, техникийн паспортыг шинэчилж, нууцын өрөөний камерыг серверийн өрөөний хаалгыг харагдахуйцаар тохируулав. Мөн серверийн өрөөний эмх цэгцийг хангаж, сүлжээний утсанд тэмдэглэгээ хийв.

ХАСХОМ, Нууцын ажлын талаар:

Төрийн аудитын байгууллагын албан тушаалтны ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2019.01.11-2019.01.18 өдрийн хооронд хүлээн авч нэгтгэн, тайланг хугацаанд нь ҮАГ-т хүргүүлэв. Өмнөх онуудад ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг аудит хийх тухай бүрд ажилтнуудаас гаргуулж авч байсан бөгөөд энэ оноос эхлэн ТЕГ, ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу зөвхөн ашиг сонирхлын зөрчил үүссэн үед мэдэгдлийг бэлтгэх чиглэл барьж ажиллаж байна.

“Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай

хуульд нийцсэн эсэх” аудиттай холбоотойгоор үүссэн Тэргүүлэх аудиторын мэдэгдлийг УАГ-т хүргүүлсэн ба “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн аудиттай холбоотой аудитын менежерийн гаргасан мэдэгдлийг хүлээн авч бүртгэн шилэн дансанд байршуулав.

Шинээр аудитораар томилогдсон 4 аудитор, албан тушаалын ангилал өөрчлөгдсөн 2 албан тушаалтны ХАСХОМ-ыг гаргуулж, хянаж баталгаажуулав.

Аудитор П.Мөнх-Эрдэнэ өөрийн хүсэлтээр ажлаас гарсан тул ХАСХОМ-ын бүртгэлээс хассан болно.

Авлигын эсрэг хууль, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус газраас 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа төлөвлөгөө гаргаж, 15 ажил хийхээр төлөвлөсний дагуу хэрэгжүүлж авлагын эсрэг санамж, самбарын мэдээлэл 800 ширхгийг хэвлэж тараасан. Мөн “Авлигыг устгахад миний оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг насанд хүрэгчид, хүүхдийн дунд зохион байгуулж байна.



Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар:


2018 онд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх танилцуулгыг бэлтгэж, албан бичгээр УАГ-т болон аймгийн Тагнуулын хэлтэст 2019 оны 01 дүгээр сарын 21-нд хүргүүлж ажиллав. Лацны бүртгэлийг өөрчлөлт орсон тухай бүр 4 удаа шинэчилж, шинээр томилогдсон 3 ажилтнаас нууцын баталгаа гаргуулав.

Архив, бичиг хэргийн хөтлөлтийн талаар:


Дарга, тэргүүлэх аудиторын 2019.04.10-ны А/10 тоот тушаалаар байгууллагын ББНШК-ыг шинэчлэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, комисс нь 2019 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан дарга, тэргүүлэх аудитораар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан.

ББНШК нь төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2019 оны 4 дүгээр сард 2018 онд хийгдсэн аудитын баримтын бүрдэлтэд шалгалт хийж дүнг удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаа.

Архив улсын үзлэг угтаж ББНШК-с тусгай төлөвлөгөө гарган ажилласны хүрээнд архивын өрөөний цонхыг битүүмжилж тохижуулан, шаардлагын дагуу тусгай өрөөнд байвал зохих галын аюулгүйн тэмдэг, галын хор, хүрз, температур болон чийг хэмжигч, элс, ус хадгалах сав, баримт зөөх уут, камержуулалт зэрэг шаардлагатай багаж хэрэгслээр бүрэн тоноглолоо.



2019 оны байгууллагын тусгай төрлийн баримт бэлтгэн архивын тасагт хүргүүллээ. Архивын улсын үзлэгийн угтаж архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос зарцуулах зөвшөөрлийг МУЕА –аас авч нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс 136 ширхэг хайрцаг архивын өрөөний шат авч 2011-2015 он хүртэлх баримтыг хайрцаглав.



Архив албан хэрэг хөтлөлтийн ажилтан солигдож байгаатай холбогдуулан 1996-2018 он хүртэлх баримтын тооллогыг хийж, баримтын жагсаалтыг шинэчлэн хийж, баримтыг байршуулсан ба он, оноор зааглагч хийн хадгаламжийн нэгж тус бүрээр бүртгэлжүүлэх ажлыг хийж дуусгасан.

Архивын улсын үзлэг угтаж Газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2019.05.16-ны А/12 тоот тушаалаар дотоод үзлэгийн хэсэг томилон аймгийн архивын газраас улсын үзлэг хийх аргачлалын дагуу байгууллагын 2017.2018.2019 оны ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтөд урьдчилсан үзлэг хийж, дүнг удирдлагад хүргүүлж, үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулж дарга,

тэргүүлэх аудиторын зүгээс хөтлөх хэргийн жагсаалтын дагуу 2017, 2018 оны байнга хадгалагдах баримтын бүрдүүлэлтэд шалгалт хийсэн.

ҮАГ-ын зөвлөн туслах ажлын хэсэг 2019.05.28-29-ны өдрүүдэд ирж ажиллаад ажил хэвийн түвшинд явагдаж байна зарим засаж, хийж хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөмж өгсөн. Архив бичиг хэргийн талаар өгсөн зөвлөмжийн дагуу дээрх ажлын хэсгээр дутуу ажлыг дахин шалгуулж архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 2014-2017 оны дугаарлаагүй болон баталгааны хуудсыг бичиж баримт нэг бүрчлэн үзэж архивын үзлэгт 100% хангаж ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр 98% буюу “маш сайн” гэж үнэлэгдэв.

Тайлант онд 2015 оны 198 хуудас баримт 2016 оны 248 хуудас баримтыг сканердаж данс бүртгэлийг хийж цахим архив мэдээллийн санд бүрэн оруулан 2018-2019 оны Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудасны тооллогыг хийж илтгэх хуудасны хамт аймгийн ЗДТГ-ын Архивын тасагт бүрэн хүлээлгэн өгсөн.

Байгууллагын хэмжээнд 2019 онд ирсэн албан бичиг 351, явсан албан бичиг 370, able программд оруулан бүртгэж анхан шатны бүртгэлийг хөтөлж холбогдох албан тушаалтанд өгч ажиллаж байна.

№	Огноо	Тамга	Тэмдэг	Хэвлэмэл	Хуудас	Баримт	Тайлбар
1	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
2	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
3	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
4	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
5	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
6	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
7	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
8	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
9	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
10	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520

№	Огноо	Тамга	Тэмдэг	Хэвлэмэл	Хуудас	Баримт	Тайлбар
1	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
2	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
3	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
4	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
5	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
6	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
7	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
8	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
9	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
10	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520

Шинэ санаачилга: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн аудит, ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын төлөвлөлтийн

№	Огноо	Тамга	Тэмдэг	Хэвлэмэл	Хуудас	Баримт	Тайлбар
1	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
2	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
3	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
4	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
5	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
6	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
7	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
8	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
9	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520
10	19.05.2019	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520	19/0520

өмнөх үе шатанд аудитын баг судалгааны 6 маягтыг боловсруулж <https://drive.google.com> онлайн системд байршуулж бүх аудиторуудын цахим хаягийг холбосноор аудиторууд хуваарилагдсан судалгааг гаргаж цахимаар нэгтгэлийг хийх боломжийг

бүрдүүлсэн нь аудитыг үр дүнтэй, цаг хугацаанд нь хийхэд чухал ажил болсон төдийгүй ҮАГ-с ирүүлсэн судалгааны нэгтгэл маягтыг гаргахад цаг хугацаа хэмнэж байна.

Долоодугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл:

Байгууллагын 2018 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, Улаанбаатар хотын “Грант Торнтон аудит” ХХК-иар аудит хийлгэн “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан. Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг тус компанид болон ҮАГ-ын Ерөнхий санхүүч Ө.Саранд хүргүүлсэн.

Байгууллагын эд хөрөнгийн эхний хагас жил, жилийн эцсийн тооллого хийх комиссыг дарга, тэргүүлэх аудиторын 2019 оны А/16, А/35 тоот тушаалаар байгуулж, тооллогыг хийж тооллогын дүнг баталгаажуулан байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулан Үндэсний аудитын газрын Орон нутаг хариуцсан ажлын албанд хугацаанд хүргүүлсэн.

Тооллогоор 2019 оны эхний хагас жилийн байдлаар ТӨБЗ-ын 2019.04.04-ний өдрийн А-4/885 тогтоолын дагуу 17 нэр төрлийн 4,1 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгах ажлыг хийгдэж холбогдох санхүүгийн тайланд тусгасан бөгөөд тооллогын дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, тооллогын дүнг баталгаажуулсан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай 2019 оны эд хөрөнгийн хариуцлагын гэрээг байгуулж, 98%-тай дүгнүүлж, дараа оны гэрээг байгуулав.

Байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн тайланг стандартын дагуу бэлтгэж 2019.07.09-ны өдөр ҮАГ –ын Орон нутаг хариуцсан ажлын албанд хүргүүлсэн ба жилийн эцсийн тайланг гаргахаар бэлтгэж байна.

2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 293,1 сая төгрөгийн төсөв батлагдсаныг зардлын бүлэг тус бүрээр зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.

МУЕА-ын 2019.09.05-ны А/67 дугаар тушаалаар нэмэлт орлогыг зарцуулах 800,0 мянган төгрөгийн эрхийг олгож нэмэлт санхүүжилтийн данснаас хангамжийн материалын зардалд зарцуулав. Мөн Монгол Улсын Сангийн Сайдын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 251 тоот тушаалаар нэмэлт санхүүжилтийн орлогоос эрх нээж өгсний дагуу 28,7 сая төгрөгийн 10,0 сая төгрөгийг нийгмийн хамгаалалтын зардалд 18,7 сая төгрөгийг зайлшгүй шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, эд хогшил авахад зарцуулна.

Тоног төхөөрөмж, эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах тендерийн үнэлгээний хороог Газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/42 тоот тушаалаар байгуулсан ба өмч хамгаалах байнгын зөвлөл үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

1. 2019 оны орлогын гүйцэтгэл: ХБГ-ээр

Санхүүжилтийн төрөл	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Хувь
Улсын төсвөөс	293,1	293,1	100%
Үндсэн үйл ажиллагааны орлого	45,1	45,1	100%

2. Зардлын гүйцэтгэл: ХБГ-ээр

Зардлын төрөл	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	194,2	194,2	100%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	25,9	25,9	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	73,0	70,6	100%
Нийт дүн	293,1	290,7	100%

Төсвийн шууд захирагчийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг боловсруулан 2019.05.20-нд ҮАГ-ын ажлын албанд хүргүүлсэн.

Төсвийн гүйцэтгэл, авлага өглөг, Нийгмийн даатгалын НД7,8 мэдээг сар бүр, Татварын тайланг гарган баталгаажуулан ҮАГ, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэст цахим болон цаасан хэлбэрээр хугацаанд нь хүргүүлсэн байна.

Шилэн дансны мэдээллийн талаар:

Шилэн дансны нэгдсэн портал сайтад болон байгууллагын веб сайтад 2019 оны ХБГ-р дүнгээр сар бүр байрлуулах 3 төрлийн 36, тухай бүр байрлуулах 8 төрлийн 96, улирал бүр байрлуулах 4 төрлийн 16 мэдээ, хагас жилээр байрлуулах 4, бүтэн жилээр байрлуулах 11 мэдээ, нийт 163 төрлийн мэдээлэл байршуулах ёстойгоос мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн.